ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/158/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2026 он | Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул<br>Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 216

танай_______________-ны №_______________-т

ЧАНДМАНЬ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Ш.НЯМСАЙХАН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалтууд, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Хөрөнгө, бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй, бараа материалын үлдэгдэлд байгаа материалыг бөөн дүнгээр шийдвэргүйгээр зарлагдсан,
- Үнэт цаасны тооцоо бодоогүй,
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй,
- Санхүүгийн тайланд авлага, өглөг, үндсэн хөрөнгө, бараа материалыг зөрүүтэй илэрхийлсэн,

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус Соёлын төв нь соёл, урлаг, номын сангийн, танхимын, кино үзвэр, хурал зөвлөгөөн, нийтийн бүжиг нийт 403 үйлчилгээг үзүүлж давхардсан тоогоор 5,795 иргэд хөдөлмөрчдийн

хамруулсан  байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд улсын төсвөөс 182.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 50.9 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.5 сая, нийт 235.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж,  сумын орон нутгийн хөгжлийн сан, улсын төсвийн хөрөнгө оруулалт, сумын түүхт 100 жилийн ойн хандиваар нийт 136.0 сая төгрөгийн хөрөнгө, 7.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан  байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 6 зорилтын 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлээр 80 хувьтай дүгнүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **33** | **АВЛАГА** | 1,670,563.23 | 3,213,460.83 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 314,511.23 | 323,708.83 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 1,533,700 |
| **335** | **Бусад авлага** | 1,356,052 | 1,356,052 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 1,356,052 | 1,356,052 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 16,060,680 | 53,281,178 |
| **351** | **Түүхий эд материал** | - | 29,590,000 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 29,590,000 |
| **354** | **Хангамжийн материал** | 16,060,680 | 23,691,178 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,442,000 | 1,430,000 |
| 35420 | Аж ахуйн материал | 380,000 | 1,585,000 |
| 35450 | Барилгын засварын материал | 250,000 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,988,680 | 20,676,178 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **17,731,243.23** | **56,494,638.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 430,323,540.99 | 514,837,892.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 424,876,791.20 | 510,762,892.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 298,651,123 | 314,151,123 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (35,265,045.34) | (43,860,452.26) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 6,500,000 | 6,500,000 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (6,500,000) | (6,500,000) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 106,825,190.73 | 240,976,400 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (55,653,414.02) | (66,558,586.53) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 54,414,317.54 | 45,411,167.03 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (28,725,232.60) | (26,534,255.07) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | - | 10,000,000 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 77,916,616 | 24,666,816 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (6,242,817.11) | (445,373.07) |
| 39217 | Ном | 12,956,053.00 | 12,956,053.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,446,749.79 | 4,075,000 |
| 39301 | Програм хангамж | 4,767,000 | 4,630,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (920,250.21) | (2,155,000) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,600,000 | 1,600,000 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **430,323,540.99** | **514,837,892.10** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **448,054,784.22** | **571,332,530.93** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,332,840.28 | 2,782,633.02 |
| **413** | **Өглөг** | 1,332,840.28 | 2,782,633.02 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 613,742.28 | 2,063,535.02 |
| **4136** | **Бусад өглөг** | 719,098 | 719,098 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 719,098 | 719,098 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,332,840.28** | **2,782,633.02** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 446,721,943.94 | 568,549,897.91 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 390,519,542 | 390,519,542 |
| 511002 | Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан | 390,519,542 | 390,519,542 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 55,733,097.94 | 177,561,051.91 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (24,354,782.59) | 54,683,537.87 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 80,087,880.53 | 122,877,514.04 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 469,304 | 469,304 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **446,721,943.94** | **568,549,897.91** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **448,054,784.22** | **571,332,530.93** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **233,916,195.52** | **233,526,400** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 188,295,695.52 | 182,647,400 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 188,295,695.52 | 182,647,400 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 45,620,500 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,620,500 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 50,879,000 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 50,879,000 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **114,347,016** | **175,049,498** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 114,347,016 | 175,049,498 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 660,000 | 1,479,500 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 460,000 | 1,479,500 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 113,687,016 | 136,070,000 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 37,499,998 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **348,263,211.52** | **408,575,898.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **268,175,330.99** | **282,231,473.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 257,902,991.43 | 272,416,187.77 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 137,657,191.35 | 150,084,668.40 |
| 210101 | Үндсэн цалин | 81,492,036.72 | 99,489,844.53 |
| 210102 | Нэмэгдэл | 44,060,355.37 | 44,227,223.87 |
| 210104 | Урамшуулал | 12,104,799.26 | 6,367,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,472,100 | 18,786,326.74 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,881,100 | 12,858,005.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,397,800 | 1,451,454.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 698,900 | 725,727.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 698,700 | 725,727.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,795,600 | 3,025,412.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,243,872.57 | 43,464,524.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 802,579.57 | 443,231.19 |
| 210302 | Түлш, халаалт | 42,741,293 | 42,741,293 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700,000 | 280,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,672,754 | 5,417,995 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,361,000 | 1,212,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,261,154 | 815,995 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 632,500 | 810,000 |
| 210404 | Ном, хэвлэл | 70,000 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,898,100 | 2,580,000 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,566,000 | - |
| 210502 | Хоол, хүнс | 1,566,000 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,075,000 | 1,460,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 500,000 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,575,000 | 1,460,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,296,000 | 604,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,296,000 | 604,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,110,000 | 2,024,000 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,300,000 | 1,874,000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 150,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 810,000 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 41,810,073.51 | 50,574,673.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,262,500 | 3,535,495 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 38,547,573.51 | 47,039,178.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,272,339.56 | 9,815,285.81 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 350,000 | 300,000 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 300,000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 350,000 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,922,339.56 | 9,515,285.81 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,745,712.13 | 5,514,475.81 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 176,627.43 | - |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,000,810 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **268,175,330.99** | **282,231,473.58** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **80,087,880.53** | **126,344,424.42** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 3,466,910.38 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 3,466,910.38 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (3,466,910.38) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **80,087,880.53** | **122,877,514.04** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **233,916,195.52** | **233,526,400** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 188,295,695.52 | 182,647,400 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 188,295,695.52 | 182,647,400 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 45,620,500 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,620,500 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 50,879,000 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 50,879,000 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **660,000** | **1,479,500** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 660,000 | 1,479,500 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 660,000 | 1,479,500 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 460,000 | 1,479,500 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000 | - |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **234,576,195.52** | **235,005,900** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **233,019,007.48** | **235,005,900** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **220,923,667.92** | **225,190,614.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 137,657,191.35 | 149,754,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 81,492,036.72 | 89,050,000 |
| 210102 | Нэмэгдэл | 44,060,355.37 | 51,066,300 |
| 210104 | Урамшуулал | 12,104,799.26 | 9,638,100 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,472,100 | 19,043,700 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,881,100 | 12,982,600 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,397,800 | 1,515,300 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 698,900 | 757,600 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 698,700 | 757,600 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,795,600 | 3,030,600 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,243,872.57 | 43,764,524.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 802,579.57 | 743,231.19 |
| 210302 | Түлш, халаалт | 42,741,293 | 42,741,293 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700,000 | 280,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,897,504 | 2,509,990 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,598,000 | 483,995 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,086,004 | 815,995 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,193,500 | 810,000 |
| 210404 | Ном, хэвлэл | 70,000 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000 | 400,000 |
| **2105** | **Нормативт зардал** | 500,000 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,408,000 | 5,000,000 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,208,000 | 3,400,000 |
| 210604 | Урсгал засвар | 1,200,000 | 1,600,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,296,000 | 604,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,296,000 | 604,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,466,000 | 2,090,000 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,216,000 | 1,940,000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 150,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,250,000 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,983,000 | 2,424,000 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,983,000 | 2,424,000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,095,339.56** | **9,815,285.81** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,173,000 | 300,000 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,193,000 | 300,000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 980,000 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,922,339.56 | 9,515,285.81 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,745,712.13 | 5,514,475.81 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 176,627.43 | - |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,000,810 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)** | **233,019,007.48** | **235,005,900** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,557,188.04** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,345,000** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,345,0000 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,345,000 | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6,345,000** | **-** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(6,345,000)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (4,787,811.96) | - |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 4,787,811.96 | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 390,519,542 | 469,304 | (24,354,782.59) | 366,634,063.41 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **390,519,542** | **469,304** | **(24,354,782.59)** | 366,634,063.41 |
| C09 | Тайлант үеийн үр дүн | - | - | 80,087,880.53 | 80,087,880.53 |
| C10 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **390,519,542** | **469,304** | **55,733,097.94** | 446,721,943.94 |
| C11 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **390,519,542** | **469,304** | **55,733,097.94** | 446,721,943.94 |
| C12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (1,049,560.07) | (1,049,560.07) |
| C13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **390,519,542** | **469,304** | **54,683,537.87** | 445,672,383.87 |
| C19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 122,877,514.04 | 122,877,514.04 |
| C20 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **390,519,542** | **469,304** | **177,561,051.91** | 568,549,897.91 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **12200** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 231,003,300 | 225,490,614.19 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 231,003,300 | 225,490,614.19 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | 231,003,300 | 225,490,614.19 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 231,003,300 | 225,490,614.19 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 230,078,900 | 225,190,614.19 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 151,288,100 | 149,754,400 |
| 210101 | Үндсэн цалин | 90,583,700 | 89,050,000 |
| 210102 | Нэмэгдэл | 51,066,300 | 51,066,300 |
| 210104 | Урамшуулал | 9,638,100 | 9,638,100 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,043,700 | 19,043,700 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,982,600 | 12,982,600 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,515,300 | 1,515,300 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 757,600 | 757,600 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 757,600 | 757,600 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,030,600 | 3,030,600 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,173,100 | 43,764,524.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,151,800 | 743,231.19 |
| 210302 | Түлш, халаалт | 42,741,300 | 42,741,293 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 280,000 | 280,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,510,200 | 2,509,990 |
| 210401 | Бичиг хэрэг | 360,000 | 483,995 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000 | 815,995 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000 | 810,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 250,200 | 400,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,065,000 | 5,000,000 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,465,000 | 3,400,000 |
| 210604 | Урсгал засвар | 1,600,000 | 1,600,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 750,000 | 604,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 750,000 | 604,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,900,000 | 2,090,000 |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | 3,750,000 | 1,940,000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000 | 150,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,348,800 | 2,424,000 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,348,800 | 2,424,000 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 924,400 | 300,000 |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 924,400 | 300,000 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | 231,003,300 | 225,490,614.19 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 5.5 | 5.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 3.5 | 3.5 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **5.5** | **5.5** |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 4 | 4 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1.5 | 1.5 |

## ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 331,477.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 321,184.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсвөөс олгосон 50,879.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тусгаагүй,
- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байгаа урлагийн хувцсыг тусгай зориулалтын материалын данс руу шилжүүлээгүй, сумын ОНХС-ийн хөрөнгөөр ойн хандиваар үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг данс бүртгэлд зөрүүтэй бүртгэсэн, акталсан хөрөнгийн элэгдлийг хасаж тайлагнаагүй, хөрөнгийн ангилал буруу сонгож 174,819.6 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- 35470  данс оны эхний үлдэгдэлд өмнөх оны материалын үлдэгдэл гэсэн утгаар бүртгэсэн бараа материалыг шууд зарлага гаргасан, үндсэн хөрөнгөөс бараа

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

материалын данс руу шилжүүлсэн нийт 39,883.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

- Авлагыг 1,542.9 мянган төгрөгөөр дутуу,
- Өр төлбөрийг 1,449.8 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүнг 47,094.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг илүү олгож тайлант оны эцэст татан төвлөрүүлсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулах бичилт 5,514.4 мянган төгрөгөөр дутуу,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д ''аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх'' заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 10,293.7 мянган төгрөгийн 3 зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 10,293.7 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс, 500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 9,793.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

### 3.1.1 Урьдчилгаа цалинтай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u> Өмнө нь ажиллаж байсан нягтлан бодогчдод 2025 оны 4 дүгээр сард 500.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгоод суутган аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэсэн заалтуудтай нийцээгүй байна.*

<u>Шийдвэрлэсэн нь</u>: *Төлбөрийн акт тогтоолоо.*

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 3.2.1 Үнэт цаасны тооцоо бодолт, дотоод хяналттай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт</u>: Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогыг данс бүртгэлд төвлөрүүлсэн ч хэдэн хэдний өдрүүд ямар урлаг уран бүтээлийн тоглолт хийж хэчнээн тасалбар зарцуулсан эсэх нь тодорхойгүй нотлох анхан шатны баримтгүй үнэт цаасны тооцоо бодоогүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2011 оны 311*

---

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

*дүгээр тогтоол Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ", 3.7-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна" 3.7.1-д " зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", 3.7.3-д "илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй , "нийцсэн бөгөөд зохистой байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангаагүй*

*.<u>Өгсөн зөвлөмж: </u> Үнэт цаасны тооцоог сар бүр бодож, соёл арга хэмжээний бүртгэл хөтөлж, төсвийн орлогын бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлж ажиллах*

*<u>Өгсөн зөвлөмж:</u> Дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангах ажиллах, үнэт цаасны тооцоог тухай бүрд нь бодох, дотоод хяналт хэрэгжүүлэх*

***3.2.2 Тооллого хийхтэй холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт: </u> Тайлант онд нягтлан бодогч нь 4 удаа солигдсон ажил хүлээлцсэн тухай анхан шатны баримтгүй, 35470 дансанд ямар бараа материал байгаа эсэх тодорхойгүй бөөн дүнгээр тусгасан, хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй, нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 12.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа, 70. 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/; гэж заасантай нийцээгүй, "үнэлгээ ба хуваарилалт", " тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.*
*<u>Өгсөн зөвлөмж: </u> Санхүүгийн тайлан гарахаас өмнө бараа материалын тооллогыг хийж хэвших, бараа материалын үлдэгдэлд бөөн дүнгээр бүртгэсэн 9,793.7 мянган төгрөгийн бараа материалыг өмнө оны санхүүгийн баримттай тулган ямар бараа материал байхыг анхан шатны баримтаас хөөн баталгаажуулах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Чандмань сумын Соёлын төв | 7 | 321,184.1 | 2 | 95,861.8 | 5 | 225,322.3 | 7 | 321,184.1 | - | - | - | - |
| Дүн | 7 | 321,184.1 | 2 | 95,861.8 | 5 | 225,322.3 | 7 | 321,184.1 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Чандмань сумын Соёлын төв | 3 | 10,293.7 | 1 | 500.0 | | | 2 | 9,793.7 | - | - | - | - |
| Дүн | 3 | 10,293.7 | 1 | 500.0 | - | - | 2 | 9,793.7 | - | - | - | - |

### ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТШЗ | - | 1 | - | - | - | 1 | - | - |
| НИЙТ | | | 1 | - | - | - | 1 | - | - |